

**АГУУЛГА**

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	2
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2. Төслийн зорилго .....	2
1.3. Баяжуулах үйлдвэрийн талбайн байршил, физик газарзүйн нөхцөл .....	2
1.4. Төслийн техник технологи, хүчин чадал .....	3
1.5. Дэд бүтэц.....	4
1.5.1. Харилцаа холбоо.....	4
1.5.2. Зам тээвэр .....	4
1.5.3. Усан хангамж .....	4
1.5.4. Цахилгаан хангамж .....	4
1.5.5. Дулаан хангамж .....	4
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт .....	5
2.1. Байгаль орчин .....	5
2.1.1. Уур амьсгал .....	5
2.1.2. Газрын гадрага .....	6
2.1.3. Геологийн тогтоц.....	6
2.1.4. Хөрсөн бүрхэвч.....	6
2.1.5. Гадаргын ус .....	6
2.1.6. Газрын доорх ус .....	7
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	8
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	9
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	10
6. Хог хаягдлын төлөвлөгөө .....	30
7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	36
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	45
9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	65
10. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....	67
11. Биологийн янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ...	68
12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	70
13. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв .....	72

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: “Хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэр” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Болоржонш” ХХК

Аж ахуй нэгжийн РД: 2830701

### 1.2. Төслийн зорилго

“Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.1 дүгээр хэсгийн заалтуудыг тус тус үндэслэн 2009 онд “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-ийг баталсан.

“Зүүн-Аргатай” ордыг түшиглэн байгуулах жонш баяжуулах үйлдвэр нь Баянжаргалан сумын 2-р багийн Энгэр-Ус нэртэй газарт байгуулагдах бөгөөд жилд 100.0 мян.т хүдэр боловсруулах хүчин чадалтай, хагас автоматчилагдсан тоног төхөөрөмжтэй, технологийн процессийн хяналтын систем, шинжилгээний лабораторитой үйлдвэр байх болно.


### 1.3. Баяжуулах үйлдвэрийн талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Дундговь аймгийн Баянжаргалан сум нь хөгжлийн бүсчлэлээр төвийн бүс нутагт, физик газарзүйн бүсчлэлээр Говийн их мужийн зүүн хэсэгт Дорнод говийн муж буюу умарт говийн гүвээт тал нутгийн талархаг гадаргуугийн баруун өмнөд хэсэгт, засаг захиргааны хувиараар баруун хойд талаараа Говь-Угтаал, зүүн хойт талаараа Говьсүмбэр аймийн Шивээговь сум, зүүн урд талаараа Өндөршил, баруун урд талаараа Гурвансайхан сум, хойд талаараа Цагаандэлгэр, зүүн талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан сумдтай хиллэн Улаанбаатар хотоос урагшаа 300км, Мандалговь хотоос зүүн хойшоо 80 км зайд байршина.

Төслийн талбай нь Баянжаргалан сумын төвөөс зүүн урагшаа 2.8 км-г 2-р багийн нутаг Энгэр-ус гэдэг газар байршина.

Хүснэгт 1. Талбайн цэгүүд

Талбайн булангийн цэгүүд	X	Y
1	108°01'25.59"E	45°44'04.44"N
2	108°01'15.69"E	45°44'19.08"N
3	108°01'28.23"E	45°44'23.24"N
4	108°01'38.13"E	45°44'08.61"N



Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил

#### 1.4. Төслийн техник технологи, хүчин чадал

ЖБҮ нь жил бүрийн хаврын 1/IV- ээс өвөл 1/XI хүртэл хуанлийн өдрийн тоо 213 хоног, нийт 176 хоног өдөрт 3 ээлж 8 цагаар 100 т/цагийн хүчин чадалтайгаар ажиллана. Үүнд:

- урсгал засвар, баяр ёслол 9 хоног,
- долоо хоногт 6 хоног ажиллана гэж тооцвол амралтын 28 хоног

Жилд ажиллах хоног 176-180

Баяжуулах үйлдвэрийн нөөц: жилд 100,000.0 т/жил  
хоногт 370 - 400 т  
цагт 15.4-16.6 т болно.

Үйлдвэрийн ашиглалтын коэффициент, 94.7%.

Хүдрийг баяжуулалтанд бэлтгэх:

- 2 шатны бутлалт
- 1 шатны нунтаглалт
- 1 шатны ангилалт.

Хөвүүлэн баяжуулах процесс (Флотаци):

- 1 шатны үндсэн флотаци
- 1 шатны хяналтын флотаци
- 7 шатны цэвэрлэгээний флотациас бүрдэнэ.

ЖБҮ нь: ▪ Урвалж бэлдэх хэсэг

- Баяжмал шүүн хатаах хэсэг
- Хаягдал хадгалах байгууламжтай байна.

## 1.5. Дэд бүтэц

### 1.5.1. Харилцаа холбоо

Баяжуулах үйлдвэрийн ойролцоох төв суурин газрууд нь харилцаа холбоо өндөр хөгжсөн бүсэд хамаарагдана. Үйлдвэр дээр үүрэн телефоны үндэсний байгууллага болох Мобиком, Жимобайл, Юнител зэрэг сүлжээ ажилладаг.

### 1.5.2. Зам тээвэр

Баяжуулах үйлдвэр нь Дундговь аймгийн Баянжаргалан сумаас 2 км зайд байрлах ба Хөөтийн нүүрсний уурхайн сайжруулсан шороон автозамаас 1.5 км зайд байрлана. Баяжуулах үйлдвэрээс 65 км зайд төмөр замын ачиж буулгах талбай байрлаж байгаа ба баяжуулах үйлдвэрээс гарах жоншны баяжмалыг төмөр замын ачиж буулгах талбай хүртэл авто тээврээр тээвэрлэх ба ачиж буулгах талбайгаас төмөр замын тээврээр тээвэрлэнэ.

### 1.5.3. Усан хангамж

Технологийн болон ахуйн хэрэгцээний усыг үйлдвэрийн ойролцоо Энгэр усны хөндий байх 2-н өрөмдмөл гүний худаг, баяжуулах үйлдвэрийн хашаанд байх нэмэгдэл нөөц бүхий гүний 1ш 30 кВ-ын насос бүхий өрөмдмөл гүний худгаас хангаж байна. Баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэх усны 70%-ийг эргэлтээр авч ашиглаж байна. Энэ нь хоногт 1361.1 м<sup>3</sup> ус байнгын эргэлтэнд байна гэсэн үг юм. Энгэр усны хөндийд гаргасан гүний худгийн ундарга 12.0 л/с байна.

### 1.5.4. Цахилгаан хангамж

#### Гадаад цахилгаан хангамж

Энгэр-Усны жонш баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг Баянжаргалан сумаас татсан 3 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар цахилгаан эрчим хүчээр хангахаар тусгав.

“Болоржонш” ХХК -ийн баяжуулах үйлдвэрийн цогцолборыг Баянжаргалан сум хүртэл татагдсан 35кВ -ийн ЦДАШ -аас 3 км 35кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам татаж, цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийн нийт суурилагдсан хүчин чадал 1389.5 кВт, бүрэн чадал 1422.9 кВт байна.

### 1.5.5. Дулаан хангамж

Баяжуулах үйлдвэр нь 4 сарын 1-ээс 11 сарын 1-ийг хүртэлжилийн 7 сарын хугацаанд ажиллана. Хүйтний 4 сарын хугацаанд уурхайн олборлолт, ЖБҮ-ийн хүдэр боловсруулалтын ажлыг түр зогсоож ажиллагсадыг амраана.

Тус дүүрэгт хавар, намрын улиралд агаарын дундаж температур +10°C ~ -20°C, өвөл нь хуурай, хүйтэн нь -15°C -ээс -25°C хүрдэг бөгөөд хавар намрын улиралд ил уурхай болон баяжуулах үйлдвэрийн барилга багууламжуудыг нам даралтын зуухаар халаахаар төсөлд тусгав.

## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1. Байгаль орчин

#### 2.1.1. Уур амьсгал

Тухайн нутаг орны уур амьсгалын нөхцөлийг бүрдүүлэх хүчин зүйлийн дотор газрын гадаргын байдал чухал байр эзэлдэг. Дундговь аймгийн Баянжаргалан сумын хувьд хотгор, гүдгэрийн ялгаа төдийлөн их биш учраас уур амьсгалын нөхцөл онцгой ялгардаггүй. Гэвч хөрс, ургамалан бүрхэвчийн байдлаас шалтгаалж, зарим нэг онцлог байдал ажиглагддаг. Их говийн нөлөөтэй бөгөөд мөн бичил уур амьсгалын өвөрмөц нөхцөл зарим газарт илэрдэг онцлогтой.

Жилийн дундаж агаарын температурын 3.50С дулаан байна. Сарын дундаж температур нь XI-III сард хүйтэн, IV-X сард дулаан утгатай буюу жилийн таван сард нь хүйтэн, долоон сард нь дулаан температуртай байна. Энэ чанараараа дулаан, хүйтний горимын хувьд аятай нөхцөлд тооцогдож байна.

Жилийн хамгийн хүйтэн нэгдүгээр сард дундаж температур нь -16.90С, хамгийн дулаан нь V сард 21.80С байх боловч, зарим өвөл -33...-350С хүртэл хүйтрэх, зун +37...+400С хүртэл халах явдал ажиглагдана .

Харин хөрсний гадарга дээр халах, хөрөх хэмжээ агаарынхаас хавьгүй их байх бөгөөд хөрсний гадаргын температурын жилийн дундаж хэм нь 6.80С байна. Өвлийн улиралд -7.30С...-16.70С, дулааны улиралд 27.10С...28.90С хооронд байна. Хөрсний гадаргад явагдах хэт халалт, хүйтний хэлбэлзэл их ажиглагддаг. Дулааны улиралд хөрсөндөө нэлээд халалт өгөх бөгөөд олон жилийн дунджаар 58.00С хүрнэ. Харин хүйтний улиралд мөн хэт хүйтэн температурын утга хөрсний гадаргад ажиглагдах бөгөөд -380С...-400С хүрнэ. Ийнхүү температурын агууригийн зөрүү их байгаа нь энэ бүс нутаг тал хээрийн бүсийн хуурай уур амьсгалтайг илэрхийлж байна.

Далай тэнгисээс алслагдсан, эх газрын эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд, түүний дотор хуурай хээр, говь бүсэд багтдаг энэ нутгийн хувьд чийг хангалтыг чухлаар авч үзэх ёстой. Дулаан, хүйтний горимын талаар дурдсан өмнөх хэсгээс үзвэл тус сумын дулаан хангалт сайн байдаг нь харагдаж байгаа боловч, бэлчээрийн ургамал ургах, улмаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өгөөж өндөр байх нөхцөлийг тодорхойлох уур амьсгалын үндсэн хүчин зүйл нь хур тунадас, чийгийн нөхцөл болдог. Жилд нутгийн баруун хойт хэсгээр 124-172 мм, дунд хэсгээр 60-99 мм, зүүн хэсгээр 33-60 мм хур тунадас орох бөгөөд түүний дийлэх хэсэг нь буюу 80-90% нь дулааны улиралд, бусад нь хүйтний улиралд ордог байна.

Дундговь аймгийн нутаг бүхэлдээ салхи ихтэй нутагт хамрагдах бөгөөд жилийн салхины дундаж хурд нь 3.9-5.6м/с-ийн хооронд хэлбэлзэнэ. Салхины хурд нь тухайн орон нутгийн хотгор, гүдгэрийн байдлаас ихээхэн шалтгаалдаг.

### **2.1.2. Газрын гадрага**

Тухайн газар нь газрын мужлалаар 2-р бүсэд хамаарна. Газрын гадаргын хувьд бэсрэг уулс, хотгор хотос, тойром, цав толгод бүхий ухаа гүвээ ээлжлэн солиглох бөгөөд төслийн талбайн баруун болон зүүн талд нам уул, цав толгод хосолсон гадарга зонхилно. Төслийн талбайд геоморфологийн үндсэн 2 хэв шинжийг ангилах боломжтой. Нам уулс, жижиг толгод, тэдгээрийн ухаа гүвээ давах хэсгийг элэгдлийн гадаргуу, уудам тал хөндий, татмын дээрх дэнж рельефийн огцом өөрчлөлтгүй тэгү тал хэсгийг зөөгдөл хуримтлалын гадаргуу гэж үзнэ.

### **2.1.3. Геологийн тогтоц**

Тухайн районы 60%-ийг ангилагддаг хурдас эзэлдэг бөгөөд түүнээс “Болоржонш” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайн орчинд хожуу протерозойн үлдэгдэл, перм, цэрдийн настай хурдсууд, дөрөвдөгч-орчин үеийн сэвсгэр хурдас гүний чулуулагтай харьцан тогтдог байна. Хожуу протерозойн хурдас нь тус районы хэмжээнд нэлэнхүйдээ тэмдэглэгддэг боловч, интузив чулуулаг дотор янз бүрийн хэмжээтэй үлдэгдэл (ксенолит) хэлбэрээр хагарал суулт даган байрладаг ажээ. Ксенолитын хэмжээ нь 1000 м x 500 м-ээс томгүй ба зарим үед 1-5 м орчим цуварсан үлдэгдлүүдээр гадаргууд цайвар зурвас үүсгэн хагарал даган байрлах нь ажиглагдана. Чухам ийм зэргэлдээ 2 зурвас тусгай зөвшөөрлийн талбайн зүүн талаас өргөргийн дагуу 3-4 км орчим үргэлжилж байдаг.

### **2.1.4. Хөрсөн бүрхэвч**

Судалгааны талбайн Монгол орны физик газарзүйн мужлалаар хээрийн бүсийн гандуу хээрийн дэд бүсэд хамаарах бөгөөд хөрс-газарзүйн мужлалтаар цайвар хүрэн хөрстэй Мандалговийн тойрогт багтана. Эндэхийн ургамалшил тачир сийрэг зарим газраа ургамалгүй цулгуй учраас салхины үйлчлэлд хялбар өртөж, хөрсний өнгөн хэсэг салхинд хийсч эвдрэх үйл явц элсэн хөрстэй газраар байнга ажиглагдана. Нам уулын орой, хяраар хадархаг, хөрсний гадарга дээр нимгэн элс, хөдөлгөөнтэй сайргархаг сайр чулуу ихтэй, чулуу нь том хэмжээтэй, хөрс их хуурайшилттай, хөрсний үе давхарга ямар нэгэн хэмжээгээр сайр чулуу агуулсан байна.

### **2.1.5. Гадаргын ус**

Баяжуулах үйлдвэрийн газар нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах бөгөөд энэ хэсэгт гадаргын усны Төв азийн гадагш урсацгүй мужид багтана. Тус сум нь бүхэлдээ усан сүлжээний хувьд гадаргын урсац саринах бүсэд оршдог. Энэ утгаараа тус ай савд багтах гол горхи хэмжээгээрээ бага, усны горимын хуьд тогтворгүй ихэнхдээ хатаж ширгэдэг байна. Төсөл хэрэгжиж буй талбайн ойр ойрчимд гадаргын ус байхгүй. Хамгийн ойр орших гадаргын ус нь төслийн талбайн зүүн зүгт 20 км зайд түр зуурын хур борооны үед бий болдог нуур байна

### 2.1.6. Газрын доорх ус

Тус районы гидрогеологийн онцлог нь тогтмол урсгалтай гол мөрөн байхгүй. Харин жижиг булгаас эх авсан Талх, Элгэн, Гашуун хар, Баруун аргатай, Алганшанд, Хужирт зэрэг нарийхан горхиудтай боловч, тэдгээр нь судалгааны талбай, түүний ойролцоо байхгүй. Горхины усны урсац бага, урт нь 100-300 метрээс хэтрэхгүй. Зуны сүүлч, намрын улиралд хааяа тохиолдох үргэлжилсэн бороо хурын дараа ихэнх хөндийнүүдэд үер буун их хэмжээний хэмхдэс материал зөөгдөн ирж хуримтлагддаг. Ус нь булингартай, хужирлаг ундны усанд тохирдоггүй. Тэдгээрээс зөвхөн Алагшанд болон Баруун Аргатайн шандын усыг нутгийн иргэд унд-ахуйн зориулалтаар ашиглаж ирсэн байна.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Гол сөрөг нөлөөллүүд		Болзошгүй сөрөг нөлөөллүүд	
Нөлөөлөл	Нөлөөллийн зэрэг	Нөлөөлөл	Нөлөөллийн зэрэг
<i>Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл</i>			
1-Тоосжилт 2-Хийн бохирдол 3-Дуу шуугиан	Дунд Дунд Дунд	1-Үнэр 2-Үйл ажиллагаа зогссон үед усны эргэлтгүй үед үүсэх үнэр 3-Техникийн эвдрэлээс үүсэх дуу чимээ /муудах/	Бага Их Дунд
<i>Газрын хэвлий, газрын гадрага, газар ашиглалтад үзүүлэх нөлөөлөл</i>			
4-Газрын хэвлий, гадаргын эвдрэл үүсэх 5-Газрын гадаргын төрх байдал өөрчлөлт орох 6-Малын бэлчээр малчдын нүүдлийн зам хуваагдах	Их Дунд Дунд	-	
<i>Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл</i>			
7-Үржил шимт хөрс хуулагдах 8-Хөрсний элэгдэл, талхагдал	Их Дунд	4-Хөрсөн бүрхэвч бохирдож үржил шимт чанараа алдах	Дунд
<i>Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл</i>			
9-Усан хангамжийн нөлөөлөл	Бага	5-Гадаргын усанд тунадас, булингар үүсч, чанар нь доройтох 6-Шатахуун түлш, барилгын материалын асгаралтаас гадаргын ус бохирдох 7-Үер усны эрсдэл 8-Газрын доорх усны бохирдол/багсалт/	Бага Дунд Бага Дунд
<i>Ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл</i>			
10-Ургамлан нөмрөг хуулагдах 11- Ургамлан бүрхэвч талхлагдаж, ургах орчин доройтох	Их Дунд	9-Тоосжилт, талхагдал, дарагдлаас ургамлан бүрхэвч гэмтэж, амьдрах чадвар нь доройтох 10- Хөрсөн бүрхэвч бохирдсоноос ургамлын амьдрах чадвар алдагдах	Дунд Дунд
<i>Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл</i>			
12-Шавьж жижиг мэрэгч, мөлхөгч амьтдын үүр оромж хөнлөгдөх 13-Амьтан үргэж дайжиж, хорогдох	Дунд Дунд	11-Шувуудын үржлийн нутаг өртөх 12- Ховор амьтны амьдрах орчин өртөх	Дунд Бага

#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус баяжуулах үйлдвэрийн төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Энэхүү төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” -ын дагуу боловсруулсан болно.


## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 5.1. Газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, чиглэлээр

#### 5.1.1. Төв замаас тухайн эдэлбэр газар хүртэл тээвэрлэлтийн болон барилгын талбай доторх замын чиглэл маршрутыг албан ёсоор гаргаж, тэмдэгжүүлэн тогтсон маршрутаар явах.

Болоржонш уурхайгаас Говьсүмбэр аймгийн Чойр хотод байрлах баяжуулах үйлдвэр хүртэл хүдэр болон баяжмалыг авто тээврээр тээвэрлэх 122 км урт бүхий авто замын маршрутыг холбогдох байгууллагуудаар хянуулж, батлуулсан.

Уг маршрут нь уурхайн олборлолтоос гарч буй хүдэр, баяжмалыг аюулгүй, тасралтгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд байгаль орчин, хүн амын суурьшил, одоо ашиглагдаж буй авто замын сүлжээнд сөрөг нөлөө багатайгаар төлөвлөгдсөн. Маршрутыг батлуулах явцад авто замын аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн даац, хөдөлгөөний зохион байгуулалт, байгаль орчны хамгааллын шаардлагуудыг харгалзан үзсэн.



**5.1.2. Олон шинэ зам үүсгэхгүй байх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлаж түүнд хяналт тавьж байх.**


Төв замаас баяжуулах үйлдвэр хүртэлх авто замын дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт 5 ширхэг анхааруулах тэмдэг, 2 ширхэг чиглэл заасан тэмдэг, мөн үйлдвэрийн нэр, хаяг бүхий 1 ширхэг мэдээллийн тэмдэглэгээг стандартын дагуу байршуулсан.

Эдгээр тэмдэг, тэмдэглэгээ нь тээврийн хэрэгслийн жолооч нарт чиг баримжаа өгөх, осол аваараас урьдчилан сэргийлэх, үйлдвэрийн байршлыг тодорхой мэдээлэхэд чиглэсэн болно



**Зураг 3. Замын тэмдэг тэмдэглэгээ**

Гэрээт тээврийн компани болох Их баян айраг ХХК-д албан тоотоор тээвэр хийж байгаа компанийн маршрут хянах GPS төхөөрөмж байрлуулах, ачааны бүтээлэгтэй тээвэр хийх, компанийн нэр бүхий хаягтай тээвэр хийх, замын төлбөрийг цаг тухайд нь төлөх гэх мэт анхааруулга мэдэгдэл өгч ажилласан. /Хавсралт 1 мэдэгдэх хуудас/



**Зураг 4. Тээврийн компанид хүргүүлсэн мэдэгдэл хуудас**

## **5.2. Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

### **5.2.1. Хүдэр ачиж, тээвэрлэх шороо тоос босгохгүйн тулд замын гадаргуу, хүдэр овоолох талбайг графикийн дагуу усалгаа хийх**

2025 оны 04-09 саруудад зам талбайн усалгааны график гаргаж үйлдвэрийн замын усалгааны хуваарийг цаг агаарын мэдээний үндэс дээр боловсруулан тоосжилтыг дарахад 150 өдөр усалгаа хийж, зам талбайг услахад 3166.8 м<sup>3</sup> ус ашигласан болно.

**Хүснэгт 2. Замын усалгааны график**

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	Нийт өдөр	Тоосжилт /м3/		
1-р сар																																	0	-	
2-р сар																																		0	-
3-р сар																																		0	-
4-р сар		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	30	546.00		
5-р сар		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	30	546.00		
6-р сар		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	30	546.00		
7-р сар		1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	24	436.80		
8-р сар		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	30	546.00		
9-р сар		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	30	546.00		
10-р сар																																	0	-	
11-р сар																																	0	-	
12-р сар																																	0	-	
<b>Нийт ажиллах хоног, тоосжилт дарах усалгааны хэмжээ /м3/</b>																															<b>174</b>	<b>3,166.80</b>			
<b>Тоосжилт дарахад: 1м2 талбайд 2 литр ус байхаар тооцно. Тоосжилт дарах талбай 9100 м2 талбай ба нийт 3166.8 м3 ус ашигласан</b>																																			



**Зураг 5. Замын усалгаа хийж буй зураг**

Үйлдвэрийн замд тогтмол усалгаа хийснээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт ойролцоогоор **60–80%**-иар бууруулж, агаарын чанар сайжирна.


Үүний үр дүнд ажилчдын эрүүл мэнд хамгаалагдаж, замын харагдах орчин сайжран хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдана.

**5.2.2. Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг хугацаанд нь хийж, оношилгоонд хамруулах**

Тоног төхөөрөмж, тээврийг хэрэгслүүдэд учирсан гэмтлийг цаг тухай бүрт нь янзалж, техникийн үзлэгийг тухай бүрт нь хянадаг. Нийт 9 машин, машинмеханизм

Ингэснээр эвдрэл, доголдол гарах нь багасч, шатахуун зарцуулалт буурна. Үүний үр дүнд хорт хий, утаа ялгаралт багасч, машин механизмын ашиглалтын хугацаа уртасан,

уурхайн үйл ажиллагаа тасралтгүй, аюулгүй, байгаль орчинд сөрөг нөлөө багатай явагдах нөхцөл бүрдэнэ. Хавсралт 2 /Техникийн үзлэгийн мэдээлэл болон, татварын баримт/



Зураг 6 Оношлогоонд оруулсан мэдээлэл

№	Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	Автын агаарын бохирдлын төлбөр	Зам ашигласны төлбөр
	686,880.00	122,400.00	1,061,000.00
	Нийт татвар		1,870,280.00

Хүснэгт 3 Автотээврийн татвар

### 5.2.3. Эвдрэл гэмтэлтэй тээврийн хэрэгслийг үйлдвэрийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх

Тээврийн хэрэгслийн эвдрэл, гэмтлийг тогтмол хянан, илэрсэн зөрчлийг цаг тухайд нь засварлан хэвийн ажиллагааг хангаж ажилласан.



Зураг 7 Автомашин засварлаж буй байдал

### 5.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

#### 5.3.1. ШТМ бохирдсон хөрс хадгалах талбайг бэлдэх, тэмдэгжүүлэх

Шатах тослох материалаар (ШТМ) бохирдсон хөрсний сөрөг нөлөөлөл цааш тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шуурхай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: ШТМ асгарах, алдагдах эрсдэл бүхий хэсгүүдэд байнгын хяналт тавьж, бохирдсон хөрсийг бусад орчноос тусгаарлан цуглуулж, түр хадгалах зохион байгуулалт хийсэн. Бохирдсон хөрсийг зориулалтын түр хадгалах цэгт байршуулж, тухайн цэгийг “Бохирдсон хөрс түр хадгалах цэг” гэсэн анхааруулах, мэдээллийн тэмдэглэгээгээр тодорхой тэмдэглэсэн.

Мөн бохирдол тархах эрсдэлийг бууруулах зорилгоор хамгаалалтын хашлага, шингээгч материал ашиглах, хөрсийг салхи, хур тунадасны нөлөөнд өртөхөөс сэргийлэх арга хэмжээг авч, улмаар бохирдсон хөрсийг холбогдох журам, стандартын дагуу цэвэрлэгээ, зайлуулалтад бэлтгэсэн.



Зураг 8. Бохирдсон хөрс түр хадгалах талбай

### 5.3.2. ШТМ бохирдсон хөрсийг цэвэрлэх, бохирдсон хөрс хадгалах цэгт хадгалах, саармагжуулах арга хэмжээ авах

Газрын тосны болон түүний дагалдах бүтээгдэхүүнээр бага хэмжээгээр бохирдсон хөрсийг цэвэрлэх аргуудыг дотор нь механик арга, физик химийн арга, биологийн арга, агротехникийн арга гэж ялгаж үзэх болно.

- Биологийн арга нь хөрсөнд нэвчсэн газрын тос болон түүний бүтээгдэхүүнийг гумины хүчлүүд, бичил биетүүдээр үйлчлэх биотехнологийн арга юм.
- Агротехникийн арга нь бохирдсон хөрсийг хадгалан сийрэгжүүлэх, эрдэс бордоогоор бордох, ургамалжуулах арга юм.

- Механик аргыг газрын тос болон түүний бүтээгдэхүүн аваар ослын үед асгарсан үед эхэнд нь хэрэглэх ба газрын гадаргуу дээрхи тунамал тогтсон түлш болон бүтээгдэхүүнийг тусгай зориулалтын насосоор соруулж авах, тос нэвчсэн хөрсийг устгалд оруулах хуулж авах.
- Физик химийн арга гэдэг нь газрын тос болон түүний бүтээгдэхүүнээр бохирдсон хөрсийг тусгай бодисуудын уусмалаар шүүрдээд дараа нь усаар шүршиж цэвэршүүлэн бохирдлыг хамж авах арга байдаг. Энд элс, хөвд, модны үртэс зэрэг шингээх чадвар сайн материалууд болрон тусгай сорбентуудад шингээж авах сорбоцын аргын хамааруулж болно. Шингээгч бодисуудыг байгууламжийн галын техник хэрэгсэлтэй хамт байрлуулах нь зүйтэй. Шингээгч энгийн бодис болох үртэс, элс зэрэг гарын доорх материалыг зохих хэмжээгээр хадгална. Шингээгч материалууд нь маш олон нэр төрлөөр дотоодын зах зээлд нийлүүлэгддэг тэндээс сонголт хийх боломжтой.

Эдгээр аргуудаас Агротехникийн аргыг сонгон авч ШТМ-аар бохирдсон хөрсийг тусгай талбай буюу 1.5 мм-ийн зузаан HDPE геомембран дэвссэн талбай бэлдэж малын бууцтай хольж түр хадгалах цэгт хадгалсан.



**Зураг 9. Агротехникийн арга хэрэглэж буй байдал**

### **5.3.3. Авто зогсоолын талбайн хайрган хучилтыг нэмэгүүлэх**

Авто зогсоолын талбайн ашиглалтын явцад үүсэх тоосжилт, шаваржилт, хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгслийн зогсолт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор тус талбайн хайрган хучилтын зузаан, талбайг нэмэгдүүлж, тэгшилгээ, нягтруулалтын ажлыг гүйцэтгэсэн.

Уг арга хэмжээний үр дүнд авто зогсоолын талбайн ашиглалтын нөхцөл сайжирч, ус тогтох, хөрс эвдрэх эрсдэл буурч, орчны цэвэр, аюулгүй байдлыг хангах боломж бүрдсэн.



**Зураг 10. Авто зогсоолын талбайн хайрган хучилтыг нэмэгдүүлсэн байдал**  
**5.3.4. Ахуйн бохирын шугам хоолойд үзлэг, шалгалт хийх Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засаж, сэлбэх**

Ахуйн бохир усны шугам хоолой эвдрэл гэмтэлгүй.

Энэхүү арга хэмжээний хүрээнд Үйлдвэрийн эргэлтийн усны шугам хоолойг засаж үзлэг хийж найдвартай ажиллагааг шалгаж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлгүй ажилласан.



**Зураг 11. Үйлдвэрийн эргэлтийн усан сангийн шугам хоолойн шалгалт**

### 5.3.5. Баяжуулах үйлдвэрийн ойр орчмын салхиар тархсан хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг зохион байгуулах

2025 оны 5 сарын 12-ны өдөр хаврын их цэвэрлэгээтэй уялдуулан үйлдвэрийн хашаанаас гадна талд буюу технологийн зам дагуу, мөн цахилгааны шугам дагуу нийт 75 га талбайг хамруулан 4 цаг цэвэрлэгээ хийж 6 м3 хогыг үйлдвэрийн хог түр хадгалах цэгт хуримтлуулав. /Цэвэрлэгээнд 1 ковш, 1 Land 76 машин, 9 хүн оролцсон болно/

2025 оны 08-р сарын 20 ны өдөр 3 хүний бүрэлдэхүүнтэй үйлдвэрийн хашаа тойрон гадна дотор талаар хог, хаягдал түүн хог хадгалах түр цэгт бөөгнүүлэв.

#### Хавсралт 3 /Үйлдвэрийн ойр орчмын цэвэрлэгээ/

	Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлууд				Ажиллах хүч	Гарсан зардал	
	Ажилласан өдөр	Ажилласан техник	Зарцуулсан шатахуун	Ажилласан хүний тоо	Цалин хөлс		
зам засвар	8	2 хово	1600	3,280,000	2	4,580,000	7,860,000
	1	5хово 1ковш	700	1,785,000	6	1,475,000	3,260,000
	0.5	5хово	250	575,000	5	687,500	1,262,500

#### Хүснэгт 4 Хог цэвэрлэгээний зардал



Зураг 12 2025 оны 5 сарын 12-ны өдрийн хаврын их цэвэрлэгээ



Зураг 13. 2025 оны 08-р сарын 20 ны өдрийн намрын их цэвэрлэгээ

### 5.3.6. Хог хаягдлын цэгийг ангилан ялгах боломжтой болгон тохижуулах

Үйлдвэр, кемпийн бүсэд үүсэж буй хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, дахин ашиглалт, зохистой

менежментийг дэмжих зорилгоор хог хаягдлын цэгүүдийг ангилан ялгах боломжтой болгон тохижуулсан.

Үүний хүрээнд дараах ангиллын хог хаягдлын цэгүүдийг тусад нь байгуулж, тэмдэглэгээ, мэдээллийн самбараар тодорхойлсон. Үүнд:

- Кемп буюу ажилчдын амьдрах орчинд ахуйн хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын хогийн цэг
- Төмрийн хаягдлыг нэг цэгт төвлөрүүлэн цуглуулж, дахин ашиглах боломжтой материалыг ялган хадгалах цэг
- Үнс болон бусад дахин ашиглах боломжгүй хаягдлыг цуглуулах тусгайлсан цэг
- Химийн бодисын сав, баглаа боодлыг бусад хаягдлаас тусгаарлан хадгалах зориулалтын цуглуулах цэг

Эдгээр арга хэмжээний үр дүнд хог хаягдлын зохистой менежмент сайжирч, орчны бохирдол буурч, холбогдох хууль, журам, стандартын шаардлагыг ханган ажилласан.



**Зураг 14. Ангилан ялгах цэгүүд**

#### **5.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

##### **5.4.1. 1м2 Раменскийн торыг тээврийн зам дагуу болон үйлдвэрийн хашаан дотор тавьж ургамлын мониторинг хийх**

Тээврийн замын дагуу болон үйлдвэрийн хашаан доторх ургамлын бүрхэвчийн төлөв байдал, зүйлийн бүрдэл, ургамлын ургалтын өөрчлөлтийг тогтмол ажиглах, хүний

үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллийг үнэлэх зорилгоор 1 м2 хэмжээтэй Раменскийн торыг сонгогдсон цэгүүдэд байршуулан ургамлын мониторингийн судалгаа хийсэн.

Мониторингийн хүрээнд ургамлын зүйлийн бүрдэл, бүрхэц, ургалтын байдал, эвдрэл доройтлын түвшинг тодорхойлж, цаашид байгаль орчны нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлтийн арга хэмжээг төлөвлөхөд ашиглах суурь мэдээллийг бүрдүүлсэн.

**Хавсралт 4 Ургамлын бичиглэл /Ургамал судлаач Зүмбэрэлмаа/**



**Зураг 15. Ургамлын мониторингийн цэг**



**Зураг 16. Урагмлын бичиглэл хийж буй зураг**

**5.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

**5.5.1. Үйлдвэрийн эргэлтийн усан санд шувуу үргээгч байрлуулах**

Үйлдвэрийн эргэлтийн усан сан орчимд шувууд бөөгнөрөх, усанд унах, үйлдвэрийн үйл ажиллагаанаас шалтгаалсан эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мөн биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бууруулах зорилгоор шувуу үргээгч 3 ширхэг төхөөрөмжийг байршуулан ашиглалтад оруулсан.

Уг арга хэмжээний үр дүнд усан сангийн аюулгүй байдал сайжирч, зэрлэг амьтдад учрах эрсдэл буурсан бөгөөд үйлдвэрийн байгаль орчны менежментийн шаардлагыг ханган ажилласан.



**Зураг 17. Шувуу үргээгч байршуулсан зураг**

#### **5.6. Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

##### **5.6.1. Тоолуурын баталгаажуулатын цаг тухай бүрт нь хийлгэх, тоолуур өвдрэл гэмтэл гарсан тухай бүр солих**

2025 оны 03 сарын 16-ны өдөр үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэх үеэр тоолуурын холболтыг хийж, холболтын ажиллагааг актлан бүртгэж, тоолуурыг лацдан баталгаажуулсан.

Энэ арга хэмжээ нь үйлдвэрийн үйл ажиллагааны эхний шатанд ус, цахилгаан болон бусад хэрэглээний хэмжилт, хяналтыг албан ёсоор бүртгэх, хяналтын нэгдсэн системд оруулах зорилготойгоор хийгдсэн. **Хавсралт 5 /Тоолуур сольсон акт, сар бүрийн тоолуурын заалт, Усны тайлан, усны төлбөр төлсөн баримт/**

Усны тоолуур холбосон гухай акт

2025.03.16 Болор Жонш ХХК

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах Болор Жонш ХХК-ны жонш баяжуулах үйлдвэрийн 2025оны үйл ажиллагаа эхлэж байна. Ийн үүрэн улмас үйлдвэрийн усны тоолуурын холболт хийж байна.

Тоолуурын заалт - D65666.

Ломбоны дугаар № 8

Тоолуур холбох үйл явцыг зураг болон бичлэгээр баталгаажуулав.

Байлцсан- Үйлдвэрийн дарга Нан Уял  
Сумын БО-ын мэргэжилтэн Сарангэрэл  
Менежер: Соймбо  
Менежер: Г.Нармандах  
Менежер: Б.Баарбаатар



Зураг 18. Эвдрэл гэмтэл засварлаж хүлээлцсэн акт

### 5.6.2. Усны тоолуурын заалтыг сар бүр сумын байгаль орчны байцаагчаар баталгаажуулах

Сар бүр усны тоолуурын заалтыг зургаар баталгаажуулан, Байгаль орчны мэргэжилтэн Х. Сарангэрэлд хүргүүлж байгаа.

Энэхүү үйл ажиллагаа нь усны хэрэглээг тогтмол хянах, бүртгэлжүүлэх, байгаль орчны хяналт, тайлангийн шаардлагыг хангах зорилготой бөгөөд тоолуурын мэдээллийг баталгаажуулсан зургаар нотолж байгаа.



Болоржонш ХХК-н үйлдвэрийн усны тоолуурын заалт 2025 оны 08 сар

Огноо	Усны тоолуур 23100099955	Төлбөр/Төг	Нийт дүн
08.31	Эхний заалт 2072.98 Эцсийн заалт 197.516 Зөрүү н3 877.8	2025	17.15246

Хянасан: Болоржонш сумын Байгаль орчны менежментийн Г.Нармандах / Г.Х.Сарангэрэл /

Тангилсан: Үйлдвэрийн дарга Нан Уял  
Боловсруулсан: Соймбо / Ч.Далан /  
Ерөнхий менежер: Г.Нармандах / Г.Нармандах /  
Заалт өссөн: ХАБЗАН-аантай: Б.Баарбаатар / Г.Нармандах /

Болоржонш ХХК-н үйлдвэрийн усны тоолуурын заалт 2025 оны 08 сар

Огноо	Усны тоолуур 23100099951	Төлбөр/Төг	Нийт дүн
08.31	Эхний заалт 2072.98 Эцсийн заалт 197.516 Зөрүү н3 877.8	2025	17.15246

Хянасан: Болоржонш сумын Байгаль орчны менежментийн Г.Нармандах / Г.Х.Сарангэрэл /

Тангилсан: Үйлдвэрийн дарга Нан Уял  
Боловсруулсан: Соймбо / Ч.Далан /  
Ерөнхий менежер: Г.Нармандах / Г.Нармандах /  
Заалт өссөн: ХАБЗАН-аантай: Б.Баарбаатар / Г.Нармандах /

Зураг 19. Тоолын заалт

**Хүснэгт 5. 2025 оны усны зарцуулалт**

2025 усны зарцуулалт						
№	Ус ашиглах хэсэг	Нийт усны хэрэглээ/ м3/	Усны эдийн засгийн суурь үнэлгээ /гүн/	Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр		Усны төлбөр
1	Технологийн усны хэрэглээнд /худгаас/	44,755.5935750	3700	0.35	1.6	92,733,589.89
2	Технологийн усны хэрэглээнд Усан санруу	33,122.0000	3700	0.35	1.6	68,628,784.00
3	Ногоон байгууламжийн усалгаанд	1,327.20	3700	0.1	0.2	98,212.80
4	Үнд ахуйн хэрэглээний ус ашиглалтанд	2,088.00	3700	0.15	1.6	1,854,144.00
5	Тоосжилт дарах	3,166.80	3700	0.2	0.25	585,858.00
6	Уурын зуух	2,040.00	3700	0.1	0.15	113,220.00
<b>нийт усны хэмжээ</b>		<b>86,500</b>				<b>164,013,808.69</b>

**Зураг 20 Усны төлбөр төлсөн баримт**

**5.6.3. Гүний ус, байгаль орчинг бохирдуулахгүй байх анхааруулга, санамж бүхий самбар хийх**

Үйлдвэрийн гүний 2 худагт “Усаа хайрлан хамгаалъя” уриатай хоёр самбар байршуулсан

Энэхүү арга хэмжээ нь худгийн усны чанар, хэмжээг хамгаалах, усны нөөцийг үр ашигтай ашиглах, ажилчдад усны хэмнэлтийн талаар мэдлэг, ухамсарыг нэмэгдүүлэх зорилготойгоор хийгдсэн. Самбаруудыг худгийн орчимд харагдахуйц байрлуулж, усны хамгааллын мэдлэгийг түгээхэд чиглүүлсэн.



Зураг 21. Усны эх үүсвэрт тавьсан урай самбар

#### 5.6.4. Булаг шандны эхийг цэвэрлэх


2025 оны 05 сарын 08-ны өдөр Мөрт булгийн ойр орчимд цэвэрлэгээний ажил гүйцэтгэсэн

Мөрт булгийн ойр орчимд 5 га талбайд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх зорилгоор зохион байгуулалттай цэвэрлэгээний ажлыг явуулж, нийтдээ ойролцоогоор 5,000 кг хог хаягдлыг цуглуулан зайлуулсан. Цэвэрлэгээний явцад хог хаягдлыг төрөлжүүлж, дахин ашиглах боломжтой хогийг тусад нь ангилан цуглуулсан бөгөөд үлдсэн хаягдлыг байгаль орчны шаардлагын дагуу зайлуулсан.

Цэвэрлэгээний үр дүнгийн талаарх мэдээллийг 2025 оны 05 сарын 12-ны өдөр Умард говийн Гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанд 25/66 тоот албан тоотоор тайлангаар хүргүүлж, тухайн бүс нутгийн байгаль орчны менежмент, хяналтын шаардлагыг хангаж ажилласан.

Энэхүү арга хэмжээ нь тухайн орчны бохирдлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих, иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлэхэд чиглэгдсэн болно.

#### Хавсралт 6 Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарлуу явуулсан тайлан



Зураг 22. Булаг шанд цэвэрлэсэн тайлан

## 5.7. Ногоон байгууламж

### 5.7.1. Усалгаа тогтмол хийх

Үйлдвэр, кемп болон авто замын дагуу байрлах ногоон байгууламжийн ургамал, мод, өвс, хашаан доторх тарьсан ургамлыг 22 өдөр усалгаа хийж 888 м<sup>3</sup> ус ашиглан усалгааг зохион байгуулсан. Усалгаа нь усны хэмнэлтийг баримтлан, ургамлын төрөл, улирлын онцлогт тохируулан явуулсан.

Усалгаа явуулахдаа дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн:

- Ургамлын үндэсний системд хангалттай ус хүргэх, хөрсний чийгийн түвшинг тогтмол барих;
- Усалгааны шугам, сав, насос, шүршигч төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд байлгах;
- Усалгааны ажлыг бичиг баримтаар бүртгэж, хяналт шалгалтыг хийж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийх;
- Ургамлын өвчлөл, үхжилтээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх арга хэмжээг холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран төлөвлөх.

Энэхүү арга хэмжээний үр дүнд ногоон байгууламжийн тогтвортой байдал сайжирч, орчны агаарын чанар, байгаль орчны амьдрах орчинд эерэг нөлөө үзүүлсэн.



Усалгаа: Ургамлын төрөл, улирлын онцлогт тохируулан тогтмол усалгааг зохион байгуулсан

Хяналт ба хамгаалалт: Ургамлын өвчлөл, үхжилтээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч ажилласан

Бүртгэл, тайлан: Тарилга, усалгааны үйл ажиллагааг бичиг баримтаар баталгаажуулж, ургамлын ургалт, хамгаалалтын хяналтыг холбогдох мэргэжилтнүүд хийсэн

**Энэхүү арга хэмжээний үр дүнд:**

Ажилчдын суурин бүсийн ногоон байгууламжийн үзэмж сайжирч, амьдрах орчны чанар дээшилсэн

Ургамлын төрөл зүйлийн олон янз байдал нэмэгдэж, хөрсний тогтвортой байдал сайжирсан

Байгаль орчны менежментийн шаардлага, нөхөн сэргээлтийн зорилтыг хангаж ажилласан

### **Хавсралт 7 /Мод тарьж буй байдал, төлбөрийн баримт/**



**Зураг 24. Үйлдвэрт тарьсан 500ш мод**

Зураг 25 Модны зарлагын баримт

## 6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 6.1. Засварын газар

#### 6.1.1. Хаягдал торх

Хавар намрын хуурайшилтын үед орон нутгийн иргэд ил задгай цогтой үнс хаяснаас үүдэн гал гарах нөхцөл бүрддэг үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрээс гарсан хаягдал торх айл өрхүүдэд тарааж өгсөн. 163 иргэн бүртгүүлж 133 иргэн хүлээн авсан.

Хавсралт 8 /хаягдал торх хүлээн авсан иргэдийн гарын үсэг/

Зураг 26. Хаягдал торх хүлээн авсан иргэдийн гарын үсэг

### 6.1.2. Шингэн: ашигласан тос, тостой холилдсон ус

Үйлдвэрийн үйл ажиллагаанд гарсан ашигласан тос, масло, бусад тослог хог хаягдлыг үйлдвэрийн тээрэм, технологийн процессд дахин ашиглах замаар хаягдалгүй ажилласан. 2025 онд нийт ашигласан тос масло 120 литр гарч бүгдийг дахин ашигласан.



Зураг 27 Тээрэмрүү тос хийж буй байдал

Энэхүү арга хэмжээ нь:

- Хаягдлын хэмжээг багасгах, хог хаягдлын менежментийг сайжруулах;
- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах;
- Нөхөн сэргээх, дахин боловсруулах боломжийг нэмэгдүүлэх;
- Үйлдвэрийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх зорилготойгоор хэрэгжүүлсэн.


Энэ үйл ажиллагааг цаашид холбогдох бүртгэл, баримтаар баталгаажуулж, байгаль орчны менежментийн стандарт, шаардлагыг хангаж ажиллах шаардлагатай.

### 6.2. Химийн бодисын сав, баглаа, боодол

Байгаль орчныг хамгаалах бодлогын хүрээнд тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгч, зайлуулах гэрээ байгуулсан.

Ашигласан материалыг тээвэрлэсэн байдал: нийт 870 кг шуудай, сав, шингэн хаягдлыг зохих журмын дагуу савлан, ачиж тээвэрлэсэн. Химийн бодисын үлдэгдэл, сав баглаа, хаягдал шуудай зэргийг “Элемент ХХК”-д нийлүүлдэг.

**Хавсралт 9 Элемент ХХК, Цэцүүх трейд ХХК аюултай хог хаягдал шилжүүлсэн акт, төлбөр төлсөн баримт, ахуйн хог хаягдлын төлбөр төлсөн баримт**



Зураг 28. Химийн бодисын сав баглаа боодол тушаасан акт, төлбөрийн баримт


### 6.3. Ахуйн хатуу хог хаягдал

Ахуйн хог хаягдал түр хадгалах цэгийг цэвэрлэж, суурийг тэгшилж янзалсан цаашид хөрс бохирдуулахаар сэргийлж доод суурийг цементлэх шаардлагатай.

Хавсралт 10 Хог хаягдлын гэрээ, төлбөр төлсөн баримт



Зураг 29. Үйлдвэрийн хог хаягдал түр хадгалах цэг



**Гүйлгээ амжилттай.**

**960,000.00 MNT**

2025.12.11 10:41

Хүлээн авагч  
Ду.Ба Хог хаягдлын хураамж  
100080500947

Гүйлгээний утга  
2251201103121

**Дуусгах**

Зураг 30 Ахуйн хог хаягдлын төлбөрийн баримт

#### 6.4. Органик хаягдал ашиглан компост бордоо хийж, ашиглах

2025 онд үйлдвэрт үүссэн органик хог хаягдлыг ашиглан компост бордоо хийхээр төлөвлөж байсан боловч тухайн жилд үйлдвэрт гахай тэжээж байсантай холбогдуулан органик хаягдлыг гахайн тэжээл болгон ашигласан тул компост бордоо үйлдвэрлэх ажил хийгдээгүй болно.

#### 6.5. Ангилан ялгасан хог хаягдлыг хүлээн авах цэгт тушаах

Үйлдвэр, кемпийн бүсэд үүссэн хог хаягдлыг төрөлжүүлж, холбогдох байгууллага, цэгт тушаан зохицуулан ажилласан. Үүнд:

##### 1. Ахуйн хог хаягдал

- Сумын төвийн нэгдсэн хогийн цэгт тушаасан.
- Тушаалтаар ахуйн хог хаягдлын зохистой менежмент, газар дээрх ариутгал, устгалын шаардлагыг хангаж ажилласан.
- Цаашид авах арга хэмжээ цаас, хуванцар сав, хоол хүнсний үлдэгдэлийг зориулалтын газарт хаяж хэвших, ажилчдад сургалт явуулах.

##### 2. Аюултай хог хаягдал

- Аюултай хог хаягдлыг (жишээ: элементүүд, химийн бодисын үлдэгдэл) Элемент ХХК-д тушаасан.
- Тушаалтаар аюултай хог хаягдлын аюулгүй хадгалалт, тээвэрлэлтийн стандарт, дүрмийн дагуу зохицуулсан.
- Ашигласан тос масло хадгалах цэг нэмж байршуулах, асгаралтын журам боловсруулан мөрдөж ажиллах

##### 3. Төмрийн хог хаягдал

- Үйлдвэрийн хашаанд түр цуглуулан хадгалж, ангилан ялган хурааж байгаа.
- Дахин ашиглах боломжтой төмрийн хог хаягдлыг “Пийс стийл групп” ХХК-д өгч, үйлдвэрлэлд дахин ашиглуулсан.
- Хаягдал төмөр авдаг байгууллага нэмж судлах, тээврийн зардал хамгийн бага байх үйлдвэрт ойр компани судлан хаягдал төмөр тушаах

№	Хог хаягдлын бүртгэл			
	Хог хаягдал	Хог хаягдал	Төрөл	Хэмжээ
1	Ахуйн хог хаягдал	Сумын төвийн хог	тонн	7.7
2	Аюултай хог хаягдал	Химийн бодисын сав баглаа	кг	870
		Ажилсан тос масло	литр	120
3	Төмрийн хог хаягдал	Хаягдал торх	ш	133

		Бусад	тн	0.8
--	--	-------	----	-----

Эдгээр арга хэмжээний үр дүнд хог хаягдлын зохистой менежмент сайжирч, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, дахин ашиглах, устгах үйл явцыг баталгаажуулсан.



Зураг 31. Хог хаягдлын цэгүүд

## 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 7.1. Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр

#### 7.1.1. Хүчтэй салхи, шуурга үед аян замд гарахгүй

##### 1. Гамшгийн мэдээллийг хянах

Радио, телевиз, гар утасны мэдээллээс шуурхай мэдээлэл авч, цаг агаарын урьдчилсан мэдээг хянах.

##### 2. Гадна агаарын нөхцөлөөс зайлсхийх

Хүчтэй салхи, цасан шуурга, бороо, манан ихтэй үед замд гарахгүй байх.

##### 3. Гэрт болон ойр орчинд бэлэн байх

Хэрэв гэрээсээ гарах шаардлага гарвал хүн, тээврийн хэрэгслийг аюулгүй газарт байрлуулах.

##### 4. Аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих

Зам, гүүр, модтой ойр орчинд гарахгүй байх; аюултай нөхцөлд хүн болон тээврийн хэрэгсэлд эрсдэл учрахыг урьдчилан сэргийлэх.

##### 5. Онцгой шаардлагатай бол зөвлөмжийг дагах

Онцгой байдлын алба, цагдаагийн зөвлөмж, анхааруулгыг чанд дагах зэрэг зөвлөмжийг гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

2025 онд Дундговь аймгийн хэмжээнд 03-р сарын 24, 9 сарын 13, 11 сарын 23-ны өдрүүдэд цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээлэл гарч байсан.

Үүнээс 2025 оны 03-р сарын 24-ний 08 цагаас 20 цаг хүртэлх цаг агаарын байдал ямар байсан тухай тойм Баянжаргалан, Дэрэн, Өндөршил сумдаар 12-14 м/с, бусад сумдаар 15-20 м/с, зарим үед 24-26 м/с хүрч цасан болон шороон шуурга шуурсан.




Зураг 32 Цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээлэл

### 7.1.2. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангах



Зураг 33. Эргэлдэгч эд ангиудын хаалт хашлагыг шинэчлэн засварласан



Зураг 34. Гүүр, суваг, шатны хаалт хашлагыг шинэчлэн засварласан



Зураг 35. Үйлчилгээний аяга, таваг, халбага сэрээ зэрэг хэрэгслийг ариутгагч төхөөрөмжөөр хэрэгжүүлдэг



Зураг 36. Хөргөгч хөлдөөгч нь агаар сэлгэлттэй, зохих температураар ажилуулдаг



Зураг 37. Ажилчдын дархалаа дэмжих бүтээгдэхүүн

### 7.1.3. Ил задгай гал гаргахгүй байх, хэрэгцээт газруудад галын самбар, багаж хэрэгслийг байршуулах

Үйлдвэр, ажилчдын кемпийн бүсэд галын аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт 5 ширхэг галын буланг байршуулсан. Үүнд:

- Ажилчдын кемп дотор
- Ажилчдын кемпийн гадна
- Үйлдвэрийн зүүн талд
- Үйлдвэрийн баруун хойно
- Химийн бодисын агуулах болон гадаад ажилчдын кемпийн орчим

Эдгээр галын булан нь галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гал гарсан тохиолдолд түргэн шуурхай арга хэмжээ авах боломжийг бүрдүүлж, ажилчдын аюулгүй байдлыг хангах зорилготойгоор байрлуулсан. Галын булан бүрийг холбогдох тэмдэг, анхааруулах самбар, шаардлагатай галын багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж ажилласан.



Зураг 38. Галын булан

### 7.1.4. Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед гадаа ажиллах ажилчдын гүйцэтгэж буй ажлыг түр зогсоох

Үйлдвэр, ажилчдын кемпийн бүсэд жил бүрийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажилладаг.

Энэхүү төлөвлөгөөний хүрээнд:

- Гал, шаталт, химийн бодисын осол зэрэг эрсдэлд урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, шалгалт, сургалт хийдэг;
- Ажилчдын гамшгаас хамгаалах мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлж, дадлага сургалтуудыг явуулдаг;
- Хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бүрэн бэлдэж, ажиллах нөхцлийг хангаж ажилласан;
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг бичиг баримтаар баталгаажуулан хянадаг.

Энэхүү арга хэмжээний үр дүнд ажилчдын аюулгүй байдал дээшилж, үйлдвэрийн үйл ажиллагаа гамшгийн эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлсэн.



Зураг 39. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө

## 7.2. Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр

### 7.2.1. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих

Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөж, хэрэгжилтэд байнга хяналт тавих ажлыг зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээний хүрээнд:

- Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврыг танилцуулж, сургалт, дадлагаар мэдлэгийг дээшлүүлсэн;
- Үйлдвэрийн бүхий л хэсэгт аюулгүй ажиллагааны стандарт, дүрэм, тэмдэглэгээ, хамгаалалтын хэрэгсэл, хувцсыг мөрдүүлж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан;
- Хяналтын бүртгэл, шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг цаг тухайд нь авч ажилласан;
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг сахиулах, эрсдэлийг бууруулах зорилгоор дотоод хяналт, аудитын системийг хэрэгжүүлсэн.

Энэхүү арга хэмжээний үр дүнд ажилчдын аюулгүй байдал дээшилж, осол, гэмтэл гарахаас урьдчилан сэргийлж, үйлдвэрийн үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангаж ажилласан.

№	Ажилчны нэвтрэл	Ажилч гурав	Гурвалжны нэг үүрэг, хариуцаж байна	Заварчилгааны хуудас
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				
11				
12				
13				
14				
15				
16				
17				
18				
19				
20				

Зураг 40. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн тэмдэглэл



Зураг 41. Мэдээллийн самбар



Зураг 42. Аюулгүй ажиллагааны самбар

### 7.2.2. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх

Үйлдвэр, ажилчдын кемпийн бүсэд ХАБЭА-н тухай ерөнхий ойлголт сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 21 хүн хамрагдсан.

Сургалтын хүрээнд:

- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны үндсэн ойлголт, дүрэм, журмын тухай мэдлэгийг олгосон;
- Ажилчдын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах аргачлалыг танилцуулсан;
- Сургалтад хамрагдсан ажилчдын мэдлэг, ур чадварыг үнэлэх, санал бодлыг авч, практик зөвлөгөө өгсөн;
- Сургалтын материалыг бичиг баримтаар баталгаажуулж, бүртгэл хөтөлсөн.

Энэхүү сургалтын үр дүнд ажилчдын ХАБЭА-н мэдлэг дээшилж, үйлдвэрийн үйл ажиллагаанд аюулгүй байдлыг хангах чадвар нэмэгдсэн.



Зураг 43. Сургалт явуулж буй байдал

### **7.2.3. Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах, хөдөлмөр хамгаалах хэрэгслийн чанар стандарт хангаж байгаа эсэхэд судалгаа хийх.**

2025 онд үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй бүх хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэг бүрийг ашиглах үеийн журам батлуулан мөрдүүлж ажилласан.

Ажилчдаас аман судалгаа авахад ажлын хувцсанд ямар нэгэн санал гомдол гараагүй боловч ажлын хувцасны өнгө жигд биш загвар өөр өөр байгаа тул стандарт батлуулж цаашид мөрдөж ажиллахаар шийдвэрлсэн. Мөн “ЭВ ИХ ГЛЮК” ХХК-иар хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулсан.

Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээгээр:

1.Ижил төстэй хөдөлмөрлөх орчны нөхцөлд ажилладаг ажил мэргэжлийн хүмүүсийн 1-р бүлэгт багтсан Бутлагч нарын ажлын байр нь “Хэвийн нөхцөл” ангиллын “Эрүүл мэндийн Дунд зэргийн эрсдэлтэй” хөдөлмөрийн нөхцөлийн ангилалд хамрагдаж байна.






## 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээг Дундговь аймгийн цаг уур орчны шинжилгээний төв, Ханлаб, Байгаль орчны хэмжилзүйн төв лаборатори, Инженер геодези, Нарт шуун консалтинг, Газарзүй геоэкологийн хүрээлэн,

Хавсралт 12 Шинжилгээний хариунууд



Зураг 47 ОХШ-ний мониторингийн цэг

### 8.1. Агаарын чанар

#### Нийт тоосны дүн шинжилгээ (2023–2025)

- 2023–2025 онд хэмжсэн нийт тоосны агууламж бүх цэгт  $0.5 \text{ мг/м}^3$ -ийн стандартаас доогуур байна.
- 2024 онд ихэнх цэгүүдэд тоосжилт өссөн ч 2025 онд буурах хандлага ажиглагдсан. Уурын зуух орчимд хамгийн өндөр ( $0.142 \text{ мг/м}^3$ ), хогийн цэг орчимд хамгийн бага ( $0.015 \text{ мг/м}^3$ ) утга бүртгэгдсэн.
- Тоосжилтын хэмжээ стандартын хязгаараас хэтрээгүй тул орчны агаарын чанар хэвийн түвшинд байна. Гэсэн хэдий ч баяжуулах үйлдвэр, карьер, бутлуур орчимд улирлын болон үйлдвэрлэлийн үед хяналт, тоос дарах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 7. Нийт тоосны шинжилгээ

Нийт тоос						
№	2023/06	2024/10	2025/1	2025/5	2025/9	MNS4585:2016
Хэмжих нэгж	$\text{мг/м}^3$	$\text{мг/м}^3$	$\text{мг/м}^3$	$\text{мг/м}^3$	$\text{мг/м}^3$	$\text{мг/м}^3$
Кемп	0.024	0.028	0.07	0.086	0.049	0.5
Баяжуулах үйлдвэр орчим			0.015	0.12	0.057	

Карьер орчим	0.026	0.019	0.097		
Уурын зуух орчим			0.142		
Хогын цэг орчим	0.015	0.054		0.066	0.051
Бутлуур	0.023	0.043		0.129	
Технологийн зам	0.021	0.087		0.03	0.058
Нөлөөллийн бүс	0.041	0.025		0.069	0.027

**Азотын агууламжийн дүн шинжилгээ (2025 он)**

- 2025 онд хэмжсэн азотын агууламжийн бүх цэгийн үзүүлэлтүүд **0.2 мг/м<sup>3</sup>-ийн стандартаас доогуур**, хэвийн түвшинд байна.
- **Кемп орчимд** азотын хэмжээ 0.022–0.03 мг/м<sup>3</sup> хооронд өссөн бөгөөд бага зэргийн нэмэгдэл ажиглагдсан ч стандартын хязгаарт багтаж байна. **Баяжуулах үйлдвэрийн орчимд** 0.02–0.044 мг/м<sup>3</sup> хүртэл өссөн нь үйлдвэрлэлийн идэвхжил нэмэгдсэнтэй холбоотой байж болох юм. **Карьер болон уурын зуух орчимд** 0.024–0.025 мг/м<sup>3</sup> орчим байсан нь тогтвортой, бага түвшний агууламжтай байна.
- **Хогийн цэг, бутлуур, технологийн зам, нөлөөллийн бүсийн** азотын агууламж 0.022–0.04 мг/м<sup>3</sup>-ийн хооронд хэлбэлзэж байгаа нь мөн стандартын доор байгаа үзүүлэлт юм.
- Ерөнхий дүнгээр, 2025 онд судлагдсан бүх байршилд азотын агууламж **хүний эрүүл мэнд болон орчны агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд байна**. Гэсэн хэдий ч баяжуулах үйлдвэр болон бутлуур орчимд **хяналт, хэмжилтийг тогтмол үргэлжлүүлэх** шаардлагатай байна.

**Хүснэгт 8. Азотын шинжилгээ**

№	Азот			MNS4585:2016
	2025/1	2025/5	025/9	
Хэмжих нэгж	мг/м <sup>3</sup>	мг/м <sup>3</sup>	мг/м <sup>3</sup>	мг/м <sup>3</sup>
Кемп	0.022	0.026	0.03	0.2
Баяжуулах үйлдвэр орчим	0.02	0.044	0.041	
Карьер орчим	0.025			
Уурын зуух орчим	0.024			
Хогын цэг орчим		0.035	0.037	
Бутлуур		0.04		
Технологийн зам		0.022	0.027	
Нөлөөллийн бүс		0.031	0.025	

**Хүхэрийн агууламжийн дүн шинжилгээ (2025 он)**

- 2025 онд хэмжсэн хүхрийн агууламж бүх цэгт **0.45 мг/м<sup>3</sup>-ийн стандартаас доогуур**, хэвийн түвшинд байна.
- **Кемп орчимд** хүхрийн хэмжээ 0.011–0.014 мг/м<sup>3</sup>-ийн хооронд байсан нь тогтвортой, бага түвшний үзүүлэлттэй байна. **Баяжуулах үйлдвэрийн орчимд** 0.015–0.023 мг/м<sup>3</sup> хүртэл өссөн нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нөлөөг

илтгэнэ. Карьер болон уурын зуух орчимд 0.01–0.012 мг/м<sup>3</sup> орчим байсан нь маш бага хэмжээтэй байна.

- Хогийн цэг, бутлуур, технологийн зам, нөлөөллийн бүсийн хүхрийн агууламж 0.01–0.02 мг/м<sup>3</sup>-ийн хооронд хэлбэлзэж байгаа нь мөн стандартаас хавьгүй доогуур үзүүлэлт юм.
- Ерөнхийд нь дүгнэхэд, 2025 онд үйлдвэрийн бүсийн бүх цэгүүдэд хүхрийн агууламж агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх түвшинд хүрээгүй, орчны нөхцөл хэвийн байна. Гэсэн хэдий ч баяжуулах үйлдвэр болон бутлуур орчимд хяналт, хэмжилтийг тогтмол хийх шаардлагатай

Хүснэгт 9. Хүхрийн шинжилгээ

Хүхэр				
№	2025/1	2025/5	2025/9	MNS4585:2016
Хэмжих нэгж	мг/м <sup>3</sup>	мг/м <sup>3</sup>	мг/м <sup>3</sup>	мг/м <sup>3</sup>
Кемп	0.011	0.014	0.014	0.45
Баяжуулах үйлдвэр орчим	0.015	0.023	0.015	
Карьер орчим	0.01			
Уурын зуух орчим	0.012			
Хогын цэг орчим		0.016	0.014	
Бутлуур		0.018		
Технологийн зам		0.013	0.013	
Нөлөөллийн бүс		0.02	0.01	

## 8.2. Хаягдал ус

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024/10	ЗДХ
pH		8.2	6,0-9,0
NH4	МгN/л	5.6	-
Cl	Мг/л	421.8	-
SO24	Мг/л	177.7	-
TDS	Мг/л	69	30
XXX	Мг/л	119	50
БХХ	Мг/л	45.76	20
NO2	МгN/л	0.1	-
NO3	МгN/л	0.49	-
Эмгэг төрөгч	1 мл-т	Илэрсэн	-

Хүснэгт 10 Хаягдал усны шинжилгээ





График 1 Эргэлтийн усны шинжилгээ ЗДХ харьцуулсан график

№	Үзүүлэлт	Элемент	Эргэлтийн ус	1-р сангийн ус	ЗДХ
1	Никель	Ni	<0.005	<0.005	<0.2
2	Кадмий	Cd	0.0194	0.014	<0.03
3	Хар тугалга	Pb	<0.005	<0.005	<0.1
4	Цайр	Zn	<0.005	<0.005	<3.0
5	Хром	Cr	<0.005	<0.005	<0.3
6	Зэс	Cu	<0.005	<0.005	<1.0
7	Хүнцэл	As	<0.005	<0.005	<0.01
8	Төмөр	Fe	6.051	3.771	<1.0
9	Бари	Ba	0.0986	0.0774	<1.5
10	Бор	B	0.352	0.387	<0.5
11	Селен	Se	<0.005	<0.005	<0.02
